



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/194

Номгон

Г Эрдэм шинжилгээний хурал зохион
байгуулах тухай Г

Орон нутгийн түүхийг мэргэжлийн түвшинд судлуулж иргэдэд танин мэдүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12/54 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 1.4.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Дашдоо гүний хошуу-Чин сүжигт Номун ханы хийд"-ийн түүх, соёл, шашны судалгаа", "Эрдэнэ засгийн хошуу-Заг Байдрагийн Хүрэн бэлчир"-ийн түүх соёлын судалгаа" сэдвээр цуврал эрдэм шинжилгээний хурлыг Архивын ерөнхий газар, Үндэсний төв архив, Түүхийн шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнтэй хамтран зохион байгуулсугай.

2.Хурал зохион байгуулах аймгийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүдэд

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Соёл, урлагийн газрын дарга

Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спортын асуудал хариуцсан мэргэжилтэн

Түүх угсаатны зүйн музейн захирал

Нийтийн номын сангийн захирал

2.

Заг сумын Засаг дарга


Галуут сумын Засаг дарга

Төрийн архивын Уншлагын танхимын ажилтан

Нарийн бичгийн дарга: Төрийн архивын дарга, Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч

3.Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулах 13,000,000 (Арван гурван сая) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулалтын өндөр түвшинд үр дүнтэй хийж, бүтээлийг эмхэтгэн, баримтжуулж материалыг Төрийн архивд шилжүүлэхийг комисс (Б.Батсүр) -т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

The image shows a handwritten signature and an official stamp. The stamp is rectangular and contains the text 'ТӨРИЙН АРХИВ' (State Archives) in the center. To the left of the stamp, the word 'ДАРГА' (Director) is written. To the right, the name 'Д.МӨНХСАЙХАН' is written. The signature is written over the stamp.